# ЗАВХАН АЙМГИЙН 2023 ОНЫ УС ЦАГ УУР, ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ТАЙЛАН



- Урьдчилсан мэдээлэл
- Цаг уур
- Хөдөө аж ахуйн Цаг уур
- Гадаргын ус судлал
- Байгаль орчны хяналт шинжилгээ
- Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаа


орт
(Улирал)
9 удаа
Урт хугацаа
(сар)12 удаа
(7 ) 52 удаа
Нислэгт 11 төрлийн урьдчилсан мэдээ, мэдээлэл
Дунд хугацаа
(5 хоног)365
удаа
(Зургаар)
365 удаа
Анхааруулга-322,
Сэрэмжлүүлэг-8,
УСМ-6 удаа
Богино хугацаа
(24 цагаар ХУМ)
365 удаа
Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллгаанд урьчилсан болон бодит мэдээ, мэдээллээр 13 удаа үйлчилсэн.
Хэт богино
хугацаа
(12 цагаар)
365 удаа

- Байгаль, цаг агаарын болзошгүй аюулт болон гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх мэдээний чанар, онч, илрүүлэлтийг сайжруулах зорилтын хүрээнд

- Онч, илэрүүлэлт-100%
- Чанар-91%
- Өмнөх оноос 4.6%-иар өссөн байна.



# Багц мэдээ



Аюулт болон гамшигт үзэгдэл болох нөхцөл бүрдсэн үед Аймаг сумдын ОК-ын гишүүд 24 сумдын иргэд, тээвэрчид, малчдад 29 удаа давхардсан тоогоор 350.991 хүнд багц мессеж дамжуулсанаас 224.225 малчдад урьдчилсан мэдээний багц мессеж хүргэсэн.

# Хуурайшилтын мэдээ




Хавар, намрын хугацаанд буюу 4 сарын 01-нээс 9 сарын 31 хүртэл нөхцөл бүрдсэн үеийн 14 цагт хуурайшлын зэргийг сум бүрээр 172 удаа бодож, түймрийн эрсдэл үнэлэн 122 удаа анхааруулга мэдээ гаргаж, сайтанд байршуулан, зурган хэлбэрээр хүргэдэг.

# ❖ Климат мэдээ

- Климат мэдээний 8 өртөөний 10 хоногийн 288, сарын 96 мэдээ дамжуулалтанд хяналт тавьж, алдаатай ирсэн 36 мэдээг тухай бүр засуулан дамжуулж ажилласан.
- Чанар 100% , өмнөх оноос 0.1%-иар өссөн байна



Цаг Уур, Орчны Шинжилгээний Газар

Ус, цаг уур, орчны ажиглалтын мэдээ дамжуулах, хяналт тавих систем

Сарын болон 10 хоногийн климат мэдээг хүснэгтээр харах цахим хуудас

2023 12 Сар Ok

2023 оны 12-р сарын климат мэдээний 1 дүгээр хэсэг

| Num | Sind | PPP | PoPoPo | TT_aver | TT_max_aver | TT_min_aver | EEE | RR_sum | RR1 | SSS | PsPsPs |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 272 | 822.7 | 1043.8 | -19.6 | -12.4 | -25.1 | 1 | 7.5 | 3 | 126 | 76 |
| 2 | 274 | 784.4 | 1057.3 | -26.6 | -19.6 | -31.9 | 0.8 | 4.7 | 1 | | |
| 3 | 221 | 863.2 | 1053.4 | -29.4 | -22.9 | -33.4 | 5.6 | 6.9 | 2 | | |
| 4 | 224 | 805.8 | 1045.9 | -24.1 | -15.6 | -31 | 0.8 | 8.7 | 3 | | |
| 5 | 225 | 829 | 1054.2 | -27.8 | -20.9 | -33.2 | 0.6 | 10.1 | 5 | | |
| 6 | 227 | 859.7 | 1047.8 | -23.5 | -16.3 | -29.7 | 0.9 | 4.6 | 3 | | |
| 7 | 219 | 865.8 | 1047.4 | -23.5 | -17.9 | -29.3 | 0.7 | 3.3 | 1 | | |
| 8 | 220 | 814.7 | 1051.1 | -25.5 | -20.8 | -30.9 | 0.8 | 8 | 2 | | |

2023 оны 12-р сарын климат мэдээний 3 дугаар хэсэг

| Sindex | TT25 | TT30 | TT35 | TT40 | TTmin0 | TTmax0 | RR01 | RR5 | RR10 | RR50 | RR100 | RR150 | SS0 | SS1 | SS10 | SS50 | FFF10 | FFF20 | FFF30 | VV50 | VV100 | VV1000 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 272 | | | | | 31 | 31 | 3 | 0 | | | | | 31 | 31 | 1 | 0 | 3 | 2 | 0 | 0 | 0 | 1 |
| 274 | | | | | 31 | 29 | 1 | 0 | | | | | 30 | 30 | 1 | 0 | | | | | | |
| 221 | | | | | 31 | 31 | 2 | 0 | | | | | 31 | 31 | 31 | 0 | | | | | | |
| 224 | | | | | 30 | 31 | 2 | 0 | | | | | 31 | 31 | 29 | 0 | 4 | 0 | 0 | | | |
| 225 | | | | | 31 | 31 | 5 | 0 | | | | | 31 | 31 | 31 | 0 | 5 | 1 | 0 | 0 | 0 | 3 |
| 227 | | | | | 31 | 28 | 3 | 0 | | | | | 31 | 31 | | | 4 | 0 | 0 | | | |
| 219 | | | | | 31 | 31 | 1 | 0 | | | | | 31 | 31 | | | 2 | 0 | 0 | | | |
| 220 | | | | | 31 | 28 | 2 | 0 | | | | | 31 | 31 | 16 | 0 | 4 | 2 | 0 | 0 | 0 | 1 |

2023 оны 12-р сарын климат мэдээний 4 дүгээр хэсэг

| Sindex | TTave_max | TTave_max_Obs_Date | TTave_min | TTave_min_Obs_Date | TT_max | Tmax_Obs_Date | TT_min | Tmin_Obs_Date | RRmax | RRmax_Obs_Date | Windmax | Windmax_Obs_Date | TStorm | Hail |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 272 | -4.6 | 12/7/2023 | -33.6 | 12/19/2023 | 2.2 | 12/4/2023 | -37.1 | 12/19/2023 | 1.8 | 12/29/2023 | 24 | 12/4/2023 | | |
| 274 | -5.2 | 12/7/2023 | -40.4 | 12/20/2023 | 1.4 | 12/6/2023 | -45.3 | 12/20/2023 | 1.3 | 12/13/2023 | 16 | 12/7/2023 | | |
| 221 | -11.2 | 12/7/2023 | -42.7 | 12/19/2023 | -4.1 | 12/7/2023 | -47.7 | 12/14/2023 | 3.3 | 12/6/2023 | 14 | 12/7/2023 | | |
| 224 | -3.4 | 12/6/2023 | -40.4 | 12/19/2023 | 1.3 | 12/6/2023 | -44.9 | 12/19/2023 | 2 | 12/7/2023 | 21 | 12/7/2023 | | |
| 225 | -3.4 | 12/7/2023 | -43.1 | 12/20/2023 | 2 | 12/6/2023 | -46.8 | 12/20/2023 | 1.7 | 12/6/2023 | 22 | 12/4/2023 | | |
| 227 | -2.9 | 12/4/2023 | -34.7 | 12/19/2023 | 4.3 | 12/6/2023 | -40.7 | 12/19/2023 | 1.6 | 12/21/2023 | 19 | 12/4/2023 | | |
| 219 | -0.7 | 12/4/2023 | -34 | 12/19/2023 | 0.4 | 12/7/2023 | -38 | 12/19/2023 | 2.9 | 12/21/2023 | 17 | 12/4/2023 | | |
| 220 | -4.7 | 12/6/2023 | -39 | 12/20/2023 | 1.5 | 12/6/2023 | -42.6 | 12/20/2023 | 2.1 | 12/30/2023 | 25 | 12/4/2023 | | |

Алдааны мэдээлэл

Буцах

# ❖ Мэдээ түгээлт

- Цаг уурын http://zavkhan.tsag-agaar.gov.mn/ сайт
- Завхан Ус цаг агаар, орчны мэдээ мэдээлэл-@Zavkhan.tsaguur пэйж хуудас: Ус цаг агаар, орчны мэдээ мэдээлэлийн пэйж 25000 гаруй хэрэглэгчийн хандалттай.
- Аймаг, сум, багийн facebook групп, пэйж хуудас:Завхан аймгийн 3 төрлийн фэйсбүүкийн нэгдсэн групп 26000 гаруй хэрэглэгч, сумдын цаг уурын фэйсбүүкд 46500 гаруй хэрэглэгч тус тус хандалт хийсэн байна.
- Утас: 92065586
- И-мэйл /ОБГ, ҮАЗ, Тагнуул, прокурор гэх мэт/
- http://alarm.tsag-agaar.gov.mn/ цаг агаарын сэрэмжлүүлэг мэдээний системд хоногоор 127, нарийвчилсан мэдээг 58 удаа тус бүр оруулж нийт 185 удаа түгээсэн
- “Уур амьсгалын үйлчилгээний систем” http://119.40.97.103/climateservice/
- https://amc.namem.gov.mn/ сайт: /Отгонтэнгэр НБ-ын 7 хоногийн төлөв 56 удаа/
- Телевиз, FM радио: / 4 удаа/
- Хурал, зөвөлгөөн /2 удаа/

# ЗАХИАЛГАТ, ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭНИЙ МЭДЭЭ

POLICE

2



БАЯН-АЙРАГТ

104




5



Шувуун хар уул

ХХК-104

ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛ

52



Аз-за зам ангид

5

Завхан
УЦУОШТ

# НИСЛЭГИЙН ЦАГ УУР




## Урьдчилсан мэдээ

Буудал орчмын урьдчилсан мэдээ /TAF/
644 удаа

Районы урьдчилсан мэдээ
313 удаа

Суултын урьдчилсан мэдээ
1 удаа

Хөөрөлтийн урьдчилсан мэдээ
152 удаа

Аэродромын урьдчилсан мэдээ
139 удаа

Чиглэлийн урьдчилсан мэдээ
120 удаа

Угталтын урьдчилсан мэдээ
35 удаа

Өндрийн салхины урьдчилсан мэдээ
139 удаа

Аэродромын сэрэмжлүүлэх мэдээ 1 удаа

Буудал орчмын 7 хоногийн урьдчилсан мэдээ
52 удаа

AIRMET мэдээ 4 удаа

Ам зөвөлгөө
139 удаа

## Бодит ажиглалтын мэдээ

Цаг уурын бодит ажиглалтын мэдээ /METAR/
1788 удаа

Цаг уурын тусгай ажиглалтын мэдээ /SPECI/ 12 удаа

AIRMET мэдээ 4 удаа

Агаарын хөлгийн мэдээ 2 удаа



Ажлын нэгдсэн дүн 98.8%, өмнөх оноос 0.5%-иар өссөн.

OTGONTENGER AIRPORT

# Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаа














- Цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэх ажлыг нийт 13 удаа, үүнээс газрын генератор 5 удаа, JFJ-1а бороoны пуужингээр 8 удаагийн үйл ажиллагаа явуулсан.
- Аймгийн хэмжээнд хуурайшилт 04 сарын 08-14-нд нийт нутгаар түймрийн эрсдэл дунд түвшин болон говийн сумдаар аюултай түвшин, 06 сарын 6-12 хооронд нийт нутгаар түймрийн эрсдэл аюултай болон нэн аюултай түвшинд хүрсэн байна. Дээрх түймрийн эрсдэлтэй ихтэй байх үеүүдэд цаг агаарын нөхцөл бүрдсэн үед үүлэнд нөлөөлөх үйл ажиллагааг зохион байгуулан ажиллаж түймрийн эрсдлийг бууруулсан.

# Агаарын температур

<u>Агаарын температурын хувьд:</u>

- Агаарын жилийн дундаж температур -1.4 градус буюу сүүлийн 30 жилийн дунджаас дулаан байсан байна.
- Агаарын дундаж температурыг бүс нутгаар нь авч үзвэл нутгийн өмнөд хэсэг болон говь талын нутгаар 2.3$^0$C...-0.1$^0$C, нутгийн хойд болон уулархаг нутгаар -4.2$^0$C...-1.4$^0$C, Отгонд -5.7$^0$C байлаа.



# Жилийн агаарын дундаж температурыг олон жилийн дундажтай харьцуулсан байдал

- Агаарын дундаж температурыг сар бүрээр нь олон жилийн дундажтай харьцуулж үзэхэд XI, XII сард дунджийн орчим, IV, V сард дунджаас хүйтэн, I–III, VI-X сардуудад дунджаас дулаан байсан ба III, IX сард олон жилийн дунджаас 5 градусаар дулаан байсан байна.
- Сум тус бүрээр харьцуулахад Дөрвөлжин, Завханмандал, Улиастай, Баянхайрхан, Нөмрөг, Тосонцэнгэл сумд олон жилийн дунджийн орчим, бусад нутгаар дунджаас дулаан байсан байна.




Сүүлийн 30 жил /1991-2020/-ийн дунджийг “Олон жилийн дундаж” гэж үзнэ.

# Агаарын хамгийн их температур

**Үнэмлэхүй их температур:**

- Энэ жилийн хамгийн их температур VII сард ажиглагдсан ба нийт сумдаар 31-36$^{0}$C хүрч дулаарсан байна.
- Агаарт 30$^{0}$C градус буюу түүнээс их дулаарсан өдөр хангайн уулархаг нутгаар 1-9, говь талын нутгаар 11-20 өдөр ажиглагдсан бол Дөрвөлжинд 27, Ургамалд 33 өдөр ажиглагдсан байна.



# Агаарын хамгийн бага температур

- Энэ жил хамгийн их хүйтрэлт XII, I, II саруудад ажиглагдаж, нутгийн хойд болон хангайн уулархаг нутгуудаар -40⁰C түүнээс давж хүйтэрсэн байна. Агаарын үнэмлэхүй бага утга 1 дүгээр сард Баянтэсд -50 градус, Тэсд -49, Отгон, Цэцэн-Уулд -48 градус хүрч хүйтэрсэн байна.
- Нутгийн хойд болон уулархаг нутгаар 2-7 өдөр, Баянтэсд 9, Тэс, Тэлмэнд 7, Тосонцэнгэлд 11, Отгонд 24 өдөр -40 градусаас их хүйтэрсэн байна.



# Хөрсний гадаргын температурын хувьд:

дундаж

- Хөрсний жилийн дундаж температур хангайн уулархаг нутгаар 2.0...-4.0$^0$C, бусад нутгаар 4.0...9.0$^0$C байсан байна.

Хамгийн их

- Говийн болон элсэрхэг хөрстэй нутгуудаар 58$^0$C...64$^0$C, бусад нутгаар 57$^0$C...60$^0$C хүрч халсан байна.

Хамгийн бага

- Хөрсөнд -40$^0$C буюу түүнээс их хүйтрэлт XII, I, II, III саруудад ажиглагдсан ба нутгийн хойд хэсгээр 6-12 өдөр, Отгонд 34, Тосонцэнгэлд 18 өдөр ажиглагдсан байна. Хамгийн хүйтэн нь I сард Отгонд -52$^0$C, Баянхайрхан, Тэс, Яруунд -50$^0$C хүрч хүйтэрсэн бол бусад нутгаар -42$^0$C...-49$^0$C хүрч хүйтэрсэн байна.

Хөрсөнд 40ºС-аас дээш халсан өдөр

- Говь талын нутгаар 73-99 өдөр
- Дөрвөлжин суманд 117 өдөр
- Бусад нутгаар 62-70 өдөр

Хөрсөнд 40ºС-аас давж хүйтэрсэн өдөр XII, I, II, III саруудад ажиглагдсан

- Нутгийн хойд хэсгээр 6-12 өдөр
- Отгон суманд 34 өдөр
- Тосонцэнгэл суманд 18 өдөр

# Хур тунадасны хувьд:




Аймгийн хэмжээнд дунджилсан жилийн нийлбэр тунадас 204.9мм буюу харьцангуй тунадас багатай жил байлаа.

# Тунадасны хазайлт:




- Нутаг дэвсгэрийн хувьд жилийн хугацаанд Түдэвтэйд 359.0мм, Их-Уулд 297.4мм, Нөмрөгт 269.8мм, Баянхайрхан 286.6мм, Завханмандалд 161.8мм буюу сүүлийн 30 жилийн дунджаас ахиу тунадас орсон бол бусад нутгаар дунджийн орчим, ганцхан Отгонд дунджаас бага хур тунадас орсон байна.
- Сар тус бүрийн тунадасны хэмжээг олон жилийн дундажтай харьцуулахад II-IV, VI, VII сард дунджаас бага I, V, IX, XI, XII сард дунджаас ахиу, VIII, X сард дунджийн орчим тунадас орсон байна. Нийт нутгаар зундаа тунадас багатай, өвлийн сардаа тунадас ихтэй байсан нь ган, зудын нөхцөл бүрдсэн байна.

# Салхи

Энэ жил нийт нутгаар дунджаар 72-111 өдөр нь 10м/с-ээс их салхитай байсан ба  Салхины хамгийн их хурд IV, V сард нийт нутгаар 18-24м/с, говь талын нутгаар 24-28м/с хүрч ширүүссэн байна.




- Мөн 4 сард хүчтэй шороон шуурга шуурсанч Сонгино, Түдэвтэйд дундаж хурд 28м/с өрөвхийлөлтөөр 40м/с, Нөмрөгт дундаж хурд 28м/с, өрөвхийлөлтөөр 34м/с хүрсэн бол ихэнх нутгаар 20-26м/с хүрч ширүүсэн, харагдах орчин хязгаарлагдан гамшигийн хэмжээнд хүрсэн байна.
- Шуурганы улмаас нийт 44 айлын гэр нурж, 99 хашаа нурж, Тосонцэнгэл сумын сургууль, Сонгино сумын сурагчдын дотуур байрны дээвэр хуурч нийтдээ 52.850.000 төгрөгийн хохирол учирсан тооцоо гарсан байна.

# Бэлчээрийн ургамлын ургац ц/га

2008-2023 он




Бэлчээрийн ургамлын бүрхэцийн үнэлгээ
51
18
30
46
20
34
53
24
23
59
17
24
40
14
46
46
16
39
10жилийн дундаж /2010-2022/
2023
Ойт хээр
10жилийн дундаж /2010-2022/
2023
Тал хээр
10жилийн дундаж /2010-2022/
2023
Цөлжүү хээр
Nogoon
Hagd
Haltsgai

## Ойт хээрийн бүс нутгийн бэлчээрийн ургамлын бүрхэцийн үнэлгээ /2010-2023 он/





Тал хээрийн бүс нутгийн бэлчээрийн ургамлын бүрхэцийн үнэлгээ /2010-2023 он/
70
60
50
40
30
20
10
0
48 17 36
44 29 28
52 26 22
59 24 18
50 27 21
52 26 22
64 21 15
37 34 30
64 19 18
58 23 19
60 22 18
54 24 22
52 21 27
59 17 24
2010 2011 2012 2013 2014 2015 2016 2017 2018 2019 2020 2021 2022 2023
Тал хээр
Nogoon Hagd Haltsgai



Цөлжүү хээрийн бүс нутгийн бэлчээрийн ургамлын бүрхэцийн үнэлгээ
/2010-2023 он/
70
60
50
40
30
20
10
0
2010: 31, 8, 61
2011: 28, 11, 61
2012: 41, 13, 47
2013: 39, 15, 46
2014: 32, 18, 50
2015: 43, 12, 44
2016: 45, 13, 43
2017: 27, 14, 59
2018: 50, 15, 35
2019: 44, 17, 40
2020: 50, 17, 34
2021: 56, 12, 33
2022: 40, 14, 46
2023: 46, 16, 39
Nogoon
Hagd
Haltsgai

# ЗУНШЛАГЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ




**Агаарын дундаж температур**: 6, 7, 8 дугаар сард агаарын дундаж температур олон жилийн дунджаас 1-3 градусаар дулаан байсан байна.

**Хур тунадас:** 6,7 дугаар сард олон жилийн дунджаас бага, 8 дугаар сард олон жилийн дундаж орчим хур тунадас орсон.

**Зун зуншлага:**

Нийт нутгийн 60 орчим хувьд хэвийн сайн, 40 орчим хувьд дунд зэрэг гэсэн үнэлгээтэй байна.




2023-2024 оны өвөл, хаврын бэлчээрийн даацыг тооцоолж гаргасан дүнгээс үзвэл аймгийн нийт нутгийн:

**59% - Хүрэлцээтэй буюу нөөцтэй**

**29%- 1-3 дахин хэтэрсэн**

**5%- 3-5 дахин хэтэрсэн**

**7% Олон дахин хэтэрсэн дүнтэй гарсан.**

# 2023-2024 ОНЫ ӨВӨЛЖИЛТИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ







Анхны цасан бүрхүүл зарим газраар 11 дүгээр сарын 3-нд тогтож, 11 дүгээр сарын 2 дугаар 10 хоногоос аймгийн нийт нутгаар битүү цасан бүрхүүлтэй тогтсон.

2024 оны 1 дүгээр сарын сүүлийн арав хоногт хийгдсэн өвлийн цасны явуул судалгааны хэмжэлтийн үр дүнгээр 24 сумын 109 багт цасны дундаж зузаан 2-40см, хунгарласан хэсэгтээ 40см -1 метр, ихэнх нутгаар цас нилээдгүй хатуурч хөрлөсөн хөрний зузаан 2-30см, цасны дундаж нягт 0.13-0.27 гр/см$^3$ байна. Цасны дундаж нягт хамгийн ихтэй байгаа нь Идэр сумын Дархан-уул, Мануустай баг 0.36-0.45г/см$^3$ , Тэлмэн сумын Баянтэгш, Нуур, Баян-Айраг 0,35-0,50г/см$^3$ байгаа нь мал бэлчээрлэлтэд хүндрэл үүсч өвс тэжээлийн хомсдолд орох нөхцөл бүрдсэн байна. Доорх зураглалыг 109 багийн цасны дундаж зузаан, нягтаар гаргалаа.

# БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ



1 АГААР

2 УС

3 ХӨРС

# <u>**Агаарын чанар:**</u>






# Агаарын чанар:






Хүхэрлэг хийн дундаж агууламж жинст орчимд 9-32мкг/м$^3$, богдын гол орчимд 8-21мкг/м$^3$, жаргалант орчимд 8-24мкг/м$^3$ байна. Чигэстэй орчимд 7-55мкг/м$^3$ байна.

Азотын азотын давхар исэлийн дундаж агууламж жинст орчимд 7-22мкг/м$^3$ богдын гол орчимд 10-33 мкг/м3 жаргалант орчимд 10-33мкг/м$^3$, Чигэстэй орчимд 10-66мкг/м$^3$, байна.

# Цацрагийн хяналт шинжилгээ:




Улиастай, Баянтэс өртөөдийн цацрагийн дүнгээс харахад 0.08-0.17 мкзв/цаг буюу хэвийн хэмжээнд байлаа.

# Усны хяналт шинжилгээ:






# Усны чанарын индексээр үнэлэхэд:



| Усны чанарын үнэлгээ | I Маш цэвэр | II Цэвэр | III Бага бохирдолтой | IV Бохирдол-той | V Бохир | VI Маш бохир |
|---|---|---|---|---|---|---|
| Индекс | ≤0.3 | 0.31-0.89 | 0.90-2.49 | 2.50-3.99 | 4.00-5.99 | 6≤ |
| 2022 он | | | | | | |
| Усны объект-харуул | Идэр-Идэр, Тэс-Баянуул, Идэр-Тосонцэнгэл/дээд, доод/, Завхан-Дөрвөлжин, Буянт-Отгон | Богд-Улиастай/дээд, доод/, Чигэстэй-Улиастай/дээд, доод/, Хүнгүй-Ургамал, Тээл-Дөрвөлжин, Хар нуур-Дөрвөлжин | | | | |
| 2023 он | | | | | | |
| | Идэр-Идэр, Тэс-Баянуул, Идэр-Тосонцэнгэл/дээд, доод/, Хүнгүй-Ургамал, Завхан-Дөрвөлжин, Тээл-Дөрвөлжин, Буянт-Отгон, Хар нуур-Дөрвөлжин | Богд-Улиастай/дээд, доод/, Чигэстэй-Улиастай/дээд, доод/ | | | | |



# Хаягдал усны хяналт






# Хөрсний төлөв байдал:



# Гадаргын ус судлал




- Цэвдгийн 3
- Химийн сорьц 12
- Биологийн дээж 6

- Голын 12
- Нуурын 2
- Газар доорх цооног 4
- Булингарын 1

**Гадаргын ус судлалын 14 харуулд Усны түвшин, өнгөрөлт, газар доорхи ус, цэвдэг, автомат түвшин, температур, тунадас хэмжигч мөн булингар, хими, биологийн дээж, гольдрилын хэмжилтийг тус тус хийж байна.**

# НЭГДСЭН ЗУРАГЛАЛ 2023 ОН

МӨН ЖИЛИЙН УД-1, УД-2 ДЭВТРҮҮДИЙГ НЭГДСЭН ЗУРАГ, ХАМААРЛЫН МУРУЙД ЗУРЖ БОЛОВСРУУЛАН ЖИЛИЙН УРСАЦЫГ ГАРГАДАГ.

Усны түвшин, өнгөрөлт, цас мөсний зузаан, мөсний үзэгдэл, тунадас, ус, агаарын температурыг зурж мөн өвлийн үзэгдэлтэй үеийн өнгөрөлтийг хатгаж боловсруулдаг.

НЭГДСЭН ЗУРАГЛАЛ УЛАМЖЛАЛТ АРГААР – 2023ОН



# НЭГДСЭН ЗУРАГЛАЛ РЕКИ-РЕЖИМ – 2023ОН




Агаар температур $t^0$

Тунадас /мм/

Усны температур $t^0$

Мөсөн дээрх цасны зузаан /см/

Мөсний зузаан /см/

Мөсний үзэгдэл

Усны түвшин /см/

Өнгөрөлт /м3/с/,

# ХАМААРЛЫН МУРУЙ - 2023 ОН

Хамаарлын муруй; Хамаарлын муруйг гол цэвэр чөлөөтэй үеийн өнгөрөлтөөр хатгах бөгөөд өнгөрөлт, усан огтлолын талбай, хурд, өмнөх оны талбай, шалгалтын өнгөрөлт, өнгөрөлт боловсруулсан сар, өдөр, хамаарлын хувь зэргийг хатган боловсруулдаг.










Хүнгүй-Ургамал харуул нь Өнгөрөлт, Усан огтлолын талбай, Дундаж хурд нь сар сардаа өөр, давхцаагүй гарсан нь элсэн гадаргуутай голын элс нүүж голын өргөн, голын гүн тогтмол өөрчлөгдсөнтэй холбоотой юм. Өнгөрөлт хэмжихдээ байнгын эхлэл, гүний босоо, хурдаа буруу тоолох, гүнээ алдаж тоолох, багажийн арчилгаа үйлчилгээс муу зэрэг алдаа гарч байна.

# ХАМААРЛЫН МУРУЙ - 2023 ОН




Буянт-Отгон харуул нь Өнгөрөлт, Усан огтлолын талбай, Дундаж хурд нь сар сардаа зөв гарч байгаа нь. Өнгөрөлт хэмжихдээ. Голын өргөн, байнгын эхлэлийн зай, гүн болон хурдны босоо, багажийн арчилгаа үйлчилгээ сайн байна.






# Газар доорхи ус

Газар доорхи усны 4 цооногт сар бүр 3 удаа усны түвшин, температурын ажиглалтын мэдээг Гадаргын ус судлалын хэлтэст хүгүүлсэн.











# Цэвдэг

Тосонцэнгэл, Идэр, Отгон сумдын цэвдгийн мэдээллийг жилд нэг удаа HOBO програмаар хураан авч Гадаргын ус судлалын хэлтэст хүргүүлсэн.









# БИОЛОГИЙН ДЭЭЖ

Биологийн дээжийг 6 харуулаас сар бүр 10 нэр төрлийн 100-150 ширхэг амьтан нийт 30 дээжийг авч Ус судлалын секторийн биологийн дээжинд явуулж шинжилгээгээр цэвэр ангилалд багтаж байна.

## ХӨВӨГЧ АМЬТДЫН ТӨЛӨӨЛӨГЧИД







## АМЬДРАХ ОРЧИН, НӨХЦӨЛ






# ГОЛЬДРОЛЫН ЗУРАГЛАЛ – 2023ОН

Чигэстэй харуулын хэв гажилтын зураглалыг 5-9 сард их, бага, дундаж түвшинд хэмжилт хийж байна.







Зураглалыг түвшин тус бүрээр QGIS програмаар 3 удаа зурж ГУССХэлтэст хүргүүлсэн.

# АВТОМАТ ХЭМЖИЛТ – 2023 ОН

Автомат түвшин хэмжигчийг Идэр-Дээд-Толгой, Тэс Баян-уул, Богд-Улиастай хауулуудад суурьлуулж бичилтийг хураан авч боловсруулалт хийсэн.

Автомат тунадас хэмжигчийг Түдэвтэй-Ойгон харуулд суурьлуулсан.















# 2023 он Төвөөс нийлүүлсэн багаж

Гадаргын ус судлалын салбаруудад дараа жилийн хэрэгцээт УД-1 дэвтэр 180ш, УД-2 дэвтэр 540ш, өртөөнд УД-6 дэвтэр 14ш мөн мөсний өрөм 2ш, усны гутал 3ш, тэмдэгтийн тросс 450м, биологийн дээжний сав 30ш, секундомер 4ш, цэвдэгийн логер 1ш, автомат тунадас хэмжигчийн холбогч 1ш, биологийн сорьцний тор 6ш, спирт 750м/л өртөө харуулаар захиалан авч хүргүүлсэн.







## Сургалт

14-н харуулын ажиглагч нарт цахим сургалтыг 3 дугаар сард, 11 дүгээр сард Газраас зохиогдсон үнэмлэх олгох сургалтанд 5 хүнийг сургасан.











сайт: [http://zavkhan.tsag-agaar.gov.mn/](http://zavkhan.tsag-agaar.gov.mn/)
Пэйж хуудас: Завхан Ус цаг агаар, орчны мэдээ мэдээлэл- [https://www.facebook.com/Zavkhan.tsaguur](https://www.facebook.com/Zavkhan.tsaguur) хуудсанд нэгдээрэй.

